

## 9

## ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН САЛБАРЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ОНЦЛОГЫН ТАЛААР

Р.Бадамханд

Өргөн уудам нутаг дэсгэртэй, харьцангуй цөөн хүн амтай, далайд гарцгүй гэх зэрэг эдийн засгийн газар зүйн онцлог нөхцөл бүхий Монгол орны хөгжлийн нэг үндэс нь хөрсөн доорхи ашигт малтмалаа зөв зохистой ашиглан байгаль экологт хор хөнөөлгүйгээр уул уурхайн салбарыг эрчимтэй хөгжүүлэх чиглэл билээ. Иймээс ч геологи, уул уурхайн салбар нь улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой тэргүүлэх салбар болон хөгжикж байна.

Геологи уул уурхайн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр энэ салбарын нягтлан бодох бүртгэлийг тухайн салбарын онцлог болон хууль эрхийн тусгайлсан нөхцөл байдалд нь зохицуулан боловсронгуй болгох шаардлага практик амьдралаас урган гарсаар байгаа юм. Тухайлбал, хайгуул судалгааны шатны зардлын ангилал, түүнийг капиталжуулах арга болоод олборлолтын уед энэ зардлыг хэрхэн хороцуулан тооцож хуваарилах гэх мэт нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС-6/-д нилээд ерөнхий байдлаар тодорхойлогдсон байдаг бөгөөд олон улс оронд дотоодын бүртгэлийн бодлого болон журамд тодорхой аргачлалыг заан мөрдлөг болгодог.

Уул уурхайн нягтлан бодох бүртгэлийн онцлогыг авч үзэхийн тулд уг салбарын үйл ажиллагааны б үндсэн үе шаттай танилцах хэрэгтэй юм. Үүнд:

- I үе – Хайгуул
- Хайгуулын ажиллагаагаар тухайн сонгосон орчинд ашигт малтмалын орд байгаа эсэхийг илрүүлэн нээдэг. Үүний тулд:
- Ашигт малтмалын анхдагч мэдээллийг ашиглах, агаарын зураг авах зэрэг аргаар тойм судалгаа шинжилгээ хийх
  - Топограф, геологи, геохими болон геофизикийн судалгаа хийх
  - Өрөмдлөг хийж, суваг малтан сорьц дээж авах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

## II үе – Үнэлгээ

Илрүүлсэн ордын нөөцийг судалж бизнес эрхлэх боломжийг тогтоох буюу доорхи ажиллагааг үнэлгээний шатанд явуулдаг:

- Ордын нөөц болон агуулгыг тогтоох
- Хүдэр баяжуулах туршилт болон металургийн судалгаа хийх
- Тээврийн асуудал болон дэд бүтцийг судлах
- Зах зээл болон санхүүжилтын боломжийг тодруулах гэх мэт.

Үнэлгээний үр дунд тухайн ордын техник эдийн засгийн үзүүлэлтийг тодорхойлох бөгөөд энэ нь уурхай ажиллуулах эсэх шийдвэрийн гол үндэслэл болдог.

## III үе – Бэлтгэл ажил

Уурхай ашиглахын өмнөх бэлтгэл ажлын хүрээнд ашигт малтмал олборлохын өмнөх ажлууд хийгддэг. Тухайлбал:

- Ус балчиг болон хөрсний доорхи лагыг зайлцуулах
- Байнгын малтталт хийх
- Зам, хонгил гаргах
- Урьдчилсан хөрс хуулалт буюу уурхайн ам нээх

## IV үе – Бүтээн босголт

Ашигт малтмал ашиглахад шаардлагдах барилга байгууламж болон зам тээврийн зохицуулалт хийгддэг. Тухайн бүсийн дэд бүтцийг хөгжүүлэх, уурхайн болон бусад зориулалтын барилга барих, машин тоног төхөөрөмж суурилуулах гэх мэт.

## V үе – Үйлдвэрлэл

Борлуулах зориулалтын бүтээгдхүүн үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэх байнгын үйл ажиллагааг үйлдвэрлэл гэдэг. Иймд уурхайн үйлдвэрлэлд ашигт малтмалын олборлолтоос эхлээд түүнийг зах зээлд борлуулах хүртэлх бүх үйл ажиллагаа хамрагдана.

## VI үе – Хаалт

Нөөцийн шавхагдал болон бусад шалтгаанаар уурхайг хаах, эсвэл өөрчлөн байгуулах арга хэмжээ авах зэрэг эрхийн үйлдвэрлэл хаагдана.

Дээрхи үе шат бүрийн өртөг зардлыг зөв тооцоход тэдгээрийн үргэлжлэх хугацаа чухал үүрэгтэй боловч хэзээ нэг үе дуусч дараагийн үе эхлэж байгааг тодорхойлох нь тийм ч хялбар бус бөгөөд түрүүчийн үйл ажиллагаа дуусаагүй байхад дараагийн шат эхлэх түүнчлэн нэг үйл ажиллагаа хэд хэдэн үе шатыг хамран хийгдэх зэрэг тохиолдол түгээмэл байдаг. Иймд бүртгэлийн аргачлалыг дараалсан үе шатуудад хамтад нь авч үзэх нь илүү зохистой гэж үздэг.

## I , II үе – Хайгуул ба Үнэлгээ

Хайгуулийн зардал зөвхөн ашигт малтмалын ордыг илрүүлэхэд зориулагддаг учир олсон ордын техник эдийн засгийн үзүүлэлт болон бизнес эрхлэх боломжийг урьдчилан тогтоох үнэлгээнд тусгайлан зардал гаргадаг. Эдгээр үе шатын хооронд зардлыг зөв хуваарилах нь тухайн зардлыг хуримтлуулан капиталжуулах эсвэл тайлант үеийн алдагдал болгон тооцоход

чухал ач холбогдолтой. Удирдлагын бодлого болон хууль журамд зохицуулан нэг хэсэг зардлыг тайлангийн хугацаанд нь ногдуулж байхад бусдыг нь хуримтлуулан бүртгэж болдог.

#### II, III үе – Үнэлгээ ба Бэлтгэл ажил

Үнэлгээ болон бэлтгэл ажлыг зааглан ялгах нь бүртгэлийн хувьд яривагтай байдаг бөгөөд урьдчилсан судалгааг явуулж дууссанаар бэлтгэл ажил эхлэлээ гэж үздэг. Ихэнхдээ урьдчилсан судалгаанд үндэслэн бэлтгэл ажил эхлэх шийдвэрийг хөрөнгө оруулагчид гаргаснаар бэлтгэл ажил эхлэн. Урьдчилсан судалгааны дүнд :

- Төслийн бизнест хэрэгжих чадвар
- Санхүүжигдэх боломж
- Зах зээлд нэвтрэлт болон урт хугацаанд нийлүүлэх гэрээ
- Уурхай ажиллуулах шийдвэр зэрэг асуудлыг тодруулдаг.

Энэхүү 2 үе шатыг зааглах шаардлага нь үнэлгээний ажлын өртгийг хайгуулын үеийн алдагдалд шууд бичих эсвэл хөгжлийн шатны ирээдүйд хуваарилагдах зардалд хуримтлуулан бүртгэхийн аль нэгийг сонгохтой холбоотой юм.

Үнэлгээний гол өртөг урьдчилсан судалгаа болон төлөвлөлтийн үеийн зардалд хамаардаг бол бэлтгэл ажлын өртөг уурхайгаас олох ашигт шууд нөлөөлнө гэж үздэг,

Уурхай ажиллуулах шийдвэр нэгэнт гарсны дараахи хайгуул болон үнэлгээний холбогдолтой зардлууд бэлтгэл ажлын өртөгт тооцогддог бөгөөд өмнө хуримтлуулсан хайгуул ба үнэлгээний ажлын өртөг нь бэлтгэл ажлын өртөг дээр нэмэгддэг.

#### III, IV үе – Бэлтгэл ажил ба Бүтээн босголт

Нэг талаас бэлтгэл ажил ба бүтээн босголтын өртгийг зааглах онц шаардлагагүй учир нь бүгд уурхай ашиглах үед хасагдах зардал юм. Гэхдээ бэлтгэл ажлын болон бүтээн босголтын өртгийг уурхайн зардалд тооцох хугацаа нь харилцан адилгүй байж болохыг анхааран үзэх хэрэгтэй. Бүтээн босголтын үед бий болсон хөрөнгийг ашиглах хугацаа уурхайг ашиглах хугацаатай адилгүй байдаг. Иймд эдгээр хөрөнгийн элэгдэл хорогдлыг янз бүрийн аргаар зөвхөн тэдгээрийн ашиглагдах хугацаанд ногдуулан тооцдог.

Бэлтгэл ажил ба бүтээн босголтын өртгийг дараахи байдлаар ялгаж болно:

- Бэлтгэл ажилд газар урьдчилан нүхлэх болон хөрсний шороог зайлцуулах гэх зэрэгтэй холбоотой зардлууд хамаарна. Эдгээр зардал нь ирээдүйн эрдэс олборлолтын ашигт хамаарах учир уурхай эхлэх хүртэл капиталждаг.
- Бүтээн босголтонд барилга, байгууламж, машин техник, тоног төхөөрөмж зэрэг биет хөрөнгийн зардал голдуу хамаарах бөгөөд эдгээр нь ашиглалтын тодорхой хугацаатай учир ашиглаж эхлэх үеэсээ зэлэгдэл тооцдог.

Бэлтгэл ажлын болон бүтээн босголтын үед тооцсон элэгдлийн зардал нь уурхай хөгжүүлэх бусад бүх зардлын хамт бэлтгэл ажлын өртөгт орж хамтдаа капиталжигдна.

#### IV, V үе – Бүтээн босголт ба Үйлдвэрлэл

Бүтээн босголт болон үйлдвэрлэлийн үе шатыг зааглах нь мөн л төвөгтэй байдаг боловч зааглах шаардлага заавал гардаг. Учир нь олборлолт буюу үйлдвэрлэл нэгэнтэй эхлэвэл дараагийн гарах зардлыг капиталжуулдаггүй зөвхөн үйл ажиллагааны зардал болгон бүртгэх хэрэгтэй болдог. Бүртгэлийн зорилгоор үйлдвэрлэлийн үе шатыг тухайн уурхай худалдаалах боломж бүхий бүтээгдхүүн гаргаж эхлэнээс зааглан тогтоох нь түгээмэл байдаг.

#### V, VI үе – Үйлдвэрлэл ба Хаалт

Хүдэрийн нөөц шавхагдах эсвэл өөр бусад шалтгаанаар уурхай хаагдах, хүдрийн хэвийн олборлолт зогсож үйлдвэрлэл үргэлжлэхээ больсноор уурхайн үйл ажиллагааг хаагдлаа гэж үздэг. Хаагдах үеийн өртөгт голчлон дараахи зардлууд ордог:

- Ажиллагсдад олгосон нөхөн олговор
- Сэргээн босголт
- Нөхөн сэргээлт болон хүрээлэн байгаа орчны зардлууд гэх мэт.

Уул уурхайн үйл ажиллагааны ашиг өмнө гарсан зардал болон алдагдлаа харьцангуй удаан хугацааны эцэст нөхөх нь тодорхой боловч хайгуул болон үнэлгээний үеийн өртгийн бүртгэл энэхүү хугацаанд нөлөөлөх нь тодорхой. Иймд хайгуулын ажиллагааны зардлыг бүртгэх аргачлал бодлого тухайн аж ахуйн нэгжийн хувьд бусад хууль тогтоомжтой зохицон тодорхойлогдсон байх нь зүйтэй юм. Юуны өмнө хайгуул ба үнэлгээний үеийн зардлын төвүүдийг тодорхойлох хэрэгтэй бөгөөд үүний тулд тухайн зардлын төвийн үүргийг авч үзнэ. Тухайлбал:

- Капиталжуулах зардлыг тодорхойлох зорилгоор
- Гарсан зардлыг төсөвтэй харьцуулан шинжлэх зорилгоор
- Бүтээгдхүүнийн өртгийг төсөвт өртөг болон урьдчилсан судалгааны үеийн тооцоололтой харьцуулах зорилгоор гэх мэт.

Хайгуулын үед чухам хана ямар ашигт малтмал олдохыг тодорхойлох боломжгүй учир зардлын нэг төвтэй байж болно. Дараа нь ашигт малтмалын нөөцтэй хэсэг тодорхой болж хайгуулын талбай хумигдаж үед зардлын төвийг хайгуулын хэсэг бүрээр тогтоох нь тохиромжтой. Өмнө нь зардлын нэг төвд хуримтлуулсан өртгийг шинээр тогтоосон төв бүрдээ ямар нэг тохиромжтой суурь сонгон авч хуваарилна.

Түүнчлэн хайгуулын зардлыг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн аргаа сонгох хэрэгтэй. Практикт дараахи 3 аргыг хэрэглэдэг. Үүнд:

- “Сонирхолын – хэсэг” /Area-of-interest method/
- “Амжилттай – нээлт” /Successful-efforts method/
- “Бүрэн - өртөг” / Full –cost method/

Эдгээрээс “Сонирхолын – хэсэг” аргыг түгээмэл хэрэглэдэг бөгөөд геологи хайгуулын ажил хийхэд хамгийн анхаарал татсан буюу ашигт

малтмалын нөөц байж болох газруудаа тодорхой хилээр зааглан тогтоож үүндээ суурилан гарсан зардал өртгөө хуваарилан бүртгэдэг. Цаг хугацааны хувьд заримдаа сонирхолын – хэсэг аргаар тогтоосон зардлын төв нь өмнө гарч хуримтлагдсан зардалд огт хамаarahгүй байх эсвэл тухайн хэсгийн нөөцийг зах зээлийн хувьд тодорхой өөрчлөлт орсны дараа ашиглах боломж бүрдэх зэргээр өртгийн хуваарилалтанд олон хүчин зүйл нөлөөлдөг. Ийм тохиолдолд зарим зардлыг дараа дараагийн шинэ хэсгүүдэд хуваарилахгүй байх нь зүйтэй.

“Амжилттай – нээлт” арга нь сонирхолын - хэсэг аргын адил зардлын төвийг эрдэс бүхий талбайгаар тогтоодог. Ялгаа нь, сонирхолын - хэсэг аргын үед хайгуулын бүрэн өртгийг эрдэс бүхий талбайд хуваарилан тооцдог бол амжилттай - нээлт аргаар бол эрдэс илэрсэн талбайд ногдох зардлыг тухайн зардлын төвийн өртөг болгон тооцох бөгөөд эрдэс илрээгүй талбайд гарсан хайгуулын зардал ба эрдэс илрүүлэхийн өмнөх зардлыг өртөгт оруулдаггүй. Амжилттай – нээлт аргыг голдуу газрын тосны хайгуулд ашигладаг.

“Бүрэн - өртөг” аргыг ашиглаадаа хайгуулын үеийн бүх зардлыг өртөгт тооцдог боловч эрдэс бүхий талбайгаар эсвэл өөр ямар нэг сууриар зардлын төвийг тогтоож тэдгээрт өртөг зардал хуваарилдаггүй онцлогтой. Энэ аргыг бүхэл бүтэн бүс, муж нутгыг хамарсан хайгуулын үед ашигладаг. Дээрхи аргуудаас 2 дахь буюу амжилттай - нээлт аргын үед хамгийн бага зардал капиталжуулдаг бол бүрэн - өртөг аргаар хамгийн их зардлыг капиталжуулна. Харин сонирхолын - хэсэг аргаар дээрхи 2 аргын дундаж хавыцаа зардал капиталжих ба зөрүү нь зөвхөн хайгуулын үед хамаарна. Энэ аргаар капиталжих зардал амжилттай - нээлт аргын үеийнхээс тодорхой ажлын үе шат дуусах бүрт зардлын ангилалаас хамаарч цаашид улам их зөрүүтэй болдог.

Тайлан гарах бүрт хайгуул ба үнэлгээний ямар зардлыг капиталжуулах, ямар зардлыг тайлант үеийн алдагдал болгон бичихийг буюу хасагдах зардалд бүртгэхийг тодорхойлж байх хэрэгтэй. Капиталжих зардлын хэмжээ ирээдүйд олох ашигиас илүүгүй байх зарчмыг баримтладаг. Ирээдүйн ашиг гэдэг нь олборлолтоор эсвэл уурхайн ашиглалтын лицензийг зарснаар олох ашиг юм. Хайгуулын үед ирээдүйд ашиг олох магадлал нь урьчилан тооцсон техник эдийн засгийн үзүүлэлтээр батлагдах хүртэл тодорхой биш байдаг. Зарим үед ирээдүйд уурхай ажиллаж ашиг олох эсэхийг тооцох боломжгүй ч ер нь ашиг олно гэсэн итгэл дээр үндэслэн хайгуул хийж их хэмжээний зардал гаргадаг бөгөөд ийм үед уг зардлыг нарийвчилсан үнэлгээ тодорхой болтол хуримтлуулна. Тухайлбал, хайгуулын зардлаа өмнө нь нөхсөн туршлага бүхий газар нутагт хайгуул хийж байгаа үед эсвэл уг газрын зах зээлийн үнэ нь гарсан зардлаас илүү байгаа үед хайгуулын зардлыг хуримтлуулна.

Үнэлгээний үеийн зардал нь хайгуулынхыг бодвол хөрөнгө болгон бүртгэх шалгуурт илүү нийцдэг. Тухайн ордын нөөц эдийн засгийн хувьд зардлаа нөхөх бүрэн боломжтой бөгөөд уурхай барих шийд нэгэнт гарсан бол

дээрхи хуримтлуулсан зардлыг капиталжуулах юм. Энэ нь үнэлгээнээс хөгжлийн шат уруу шилжих үетэй давхцна.

Хайгуул хийгч тал

а/ хайгуулын зардлаа уг хайгуул бүрэн зогсоож гарсан зардал бүгд алдагдал болтол,

б/ хайгуул амжилттай болж хөгжлийн шат эхлэн өмнөх зардлыг капиталжуулах хүртэл эсвэл

в/ хайгуул хийсэн талбайгаа зарах хүртлээ хуримтлуулж болно.

Энэ нь хөрөнгө бүртгэх зарчмийг төдийлөн харшлахгүй боловч зарим тохиолдолд нотлоход хүндрэлтэй байдаг талтай.

Уурхайн томоохон компаниудын хувьд шинээр хайгуул хийхдээ гарсан зардлыг голдуу тайлант үеийн зардлаа болгох эсвэл түр хуримтлуулах аргаар бүртгэдэг. Тайлант үеийн зардал шууд бүртгэхдээ доорхи 2 хандлагыг баримтладаг:

1. хайгуулын бизнес зорилгыг тодруулах хүртэл зардлыг шууд тайлант хугацаанд нь бүртгээд дараагийн зардлуудыг хуримтлуулж эхлэх

2. хайгуулын эхний шатны зардлыг шууд бүртгээд үнэлгээ эхлэж тухайн ордын эдийн засгийн үзүүлэлт нааштай болоход хуримтлуулан бүртгэж эхлэх

Хэрэв тухайн хайгуулын үр дүн тодорхой бус буюу хөгжлийн шат эхлэх эсвэл худалдах шийдвэр гараагүй бол хайгуул судалгааны зардлыг түр хуримтлуулан бүртгэдэг. Хайгуулыг зогсоовол уг зардлыг бүрэн хасагдуулах буюу алдагдал болгоно. СТОУС-д хайгуулын зардлыг алдагдал болгох шалгууруудыг тодорхойлсон байдаг. Харин цаашид хөгжлийн шат эхлэхээр болбол уг зардлыг жил бүр гарах дараагийн шатны зардлууд дээр нэмж зөвхөн нөөц бүхий ордын хэсэгт ногдуулан хуваарилж капиталжуулна. Ийнхүү хайгуулын ажлын ирээдүй тодорхой бус байх үед гарсан хайгуул судалгааны зардлыг шууд тайлант хугацааны зардалд бүртгэх эсэл түр хуримтлуулах арга өргөн хэрэглэдэг боловч хайгуул амжилттай болж дараа дараагийн үе шатууд эхлэх нь тодорхой болсон тохиолдолд шууд бичигдсэн болон түр хуримтлуулсан зардлыг дахин сэргээн авч үздэг. Гэхдээ нэгэнт гарсан зардлыг эргэж капиталжуулах нь СТОУС-д нийцдэггүй бөгөөд хайгуул судалгааны ажлын хувьд стандартад тусгайлан авч үзсэн заалтууд нь нилээд маргаантай асуудлуудын нэг байсаар байна.

Хөгжлийн болон бүтээн босголтын зардлыг капиталжуулах эсэх сонголт хийх шаардлага төдийлөн байдаггүй учир нь эдгээр шат нь тухайн ордын ирээдүйн эдийн засгийн үр өгөөжийг зохих хэмжээнд тодорхойлсны дараа хийгдэж байгаа ажил билээ. Харин ямар зардлыг капиталжуулах ямрыг нь шууд бүртгэх талаар авч үзэх шаардлагатай. Үүний тулд зардлыг шууд ба шууд биш зардал гэж ангилна. Шууд зардал нь ирээдүйн үр ашигийг шууд хангаж буй олборлолт хийх хайгуулын талбайд тусгайлан шууд хамааралтай байна. Ерөнхий удирдлага болон өөр бусад хайгуулын талбайд хамаарах зардал нь шууд бүс зардал байна. Удирдлагын зардлаас олборлолт хийх

талбайд ногдуулан хуваарилж капиталжуулж болох бөгөөд үүний тулд маш зөв үндэслэл гаргахыг стандарт шаарддаг.

Аль ч үе шатанд хэрэглэж байгаа биет хөрөнгө буюу байгууламж, тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгслийг хөрөнгөнд бүртгэж тэдгээрийн ашиглагдах хугацаанд нь элэгдэл тооцдог. Элэгдлийн зардал нь бусад зардлын адил капиталжих эсвэл хасагдах байдлаар бүртгэгдэнэ.

Улсын өмчид байгаа болон засгийн газартай хамтарсан зарим уурхайн хувьд уг уурхайн албан ёсны өмч биш боловч түүний бүрэн эзэмшилд байгаа хөрөнгүүд байдаг. Тухайлбал, ус хангамжийн болон цахилгаан станцын байгууламжууд, хотын болон орон нутгийн шугам сүлжээний хэсэг гэх мэт. Уурхайн лицензтэй хамт эдгээрийг ашиглах эрх өгөгдсөн байdag тул холбогдох зардлыг тусгайлан бүртгэж шууд капиталжуулах эсвэл хөрөнгөнд бүртгэж элэгдэл тооцохоо уг хөрөнгийн мөн чанараас хамааран тодорхойлох хэрэгтэй байдаг.

Хайгуул судалгааны ажлыг уурхайн компаниуд зээлээр төдийлөн санхүүжүүлдэггүй учир энэ үеийн зардалд зээлийн хүүг капиталжуулах асуудал бараг гардаггүй. Мөн олонхи жижиг компаниудын хувьд санхүүжүүлэх эх үүсвэр нь эзэмшигчийн өмч байдаг.

Гэхдээ урт удаан хугацаанд олж бэлтгэх, барьж байгуулах болон үйлдвэрлэх шаардлагатай хөрөнгийг санхүүжүүлэх зориулалтаар зээл аван зарцуулсан үед НББОУС-23 “Зээлийн зардал” –д зааснаар зээлийг түүний хүү болон банкны холбогдох бусад зардлын хамт капиталжуулдаг бөгөөд дараахи хэдэн нөхцлийг харгалзах хэрэгтэй. Үүнд:

- Уг зээл нь тусгай зориулалтын ч бай байгууллагын ерөнхий зорилго бүхий зээлийн хэсэг ч бай хөрөнгөнд заавал зарцуулагдсан байх ёстой
- Зээлийн болон түүнтэй холбогдох зардал заавал гарсан үед хүүг капиталжуулна
- Уурхайн гол үйл ажиллагаа эхлэсэн үеэс хүүгийн капиталжуулалтыг зогсоох ба энэ үед өмнө нь хийгдээгүй хөгжлийн болон бүтээн босгох ажил үргэлжлэн хийгдсэн ч хүүг үргэлжлүүлэн капиталжуулахгүй
- Хөрөнгө бэлтгэхэд авсан тусгай зориулалтын зээлийн зөвхөн цэвэр хүүг буюу нийт зээлийн дүнд төлсөн хүүгээс зээлийн сангийн үлдэгдэлд ногдох хүүг хассан дүнг капиталжуулна.

Бүтээн босголтын ажлыг гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгаа үед гадаад валютын ханшийн зөрүүний ашиг, алдагдлыг НББОУС - 21 “Гадаад валютын ханшийн зөрүүгийн нөлөөлөл” –д заасан дагуу доор заасан 2 тохиолдоос бусад үед тайлант хугацаанд хамааруулан бүртгэнэ.

- Хохиролоос сэргийлэх даатгал хийлгээгүй нөхцөлд валютын ханшийн гэнэтийн уналтаас их хэмжээний зөрүү гарахад хөгжил болон бүтээн босголтыг шууд санхүүжүүлсэн дүнд ногдох хэсгийг капиталжуулах

- Ханшийн зөрүүг зээлийн хүүтэй адилтган үзэж НББОУС 23-ын дагуу капиталжуулах.

Хайгуул судалгааны ба хөгжил, бүтээн босголтын зардлын талаар хийх нэмэлт тодруулгын тусгай стандарт байдаггүй ч санхүүгийн тайландаа доорхи тодруулгыг хийвэл зохилтой байдаг.

- Хайгуул судалгаа ба үнэлгээний ажлын зардлын талаар
- Хайгуулын үе болон үнэлгээний үеийн зардлын бүртгэлийн бодлого
- Шууд зардал тооцсон дүн
- Түр хуримтлуулсан зардлын дүн
- Эргэж капиталжуулагдсан зардал
- Капиталжуулсан зардлын дүнгийн тохиргоо гэх мэт

Хөгжил ба бүтээн босголтын үеийн зардлын талаар :

- Бүтээгдхүүн гаргалтаас хойши хүийг хамруулсан бүртгэлийн бодлого
- Капиталжуулсан зардлын нийт дүн
- Үйлдвэрлэл явуулах нь тодорхой болсон төсөлд капиталжуулсан зардал
- Өмнөх жилүүдийн өртгийн тохиргоо гэх мэт.

Уурхайн үйл ажиллагааны зардлын талаар:

- Бүртгэлийн бодлого / элэгдэл, хорогдлын талаар багтаасан/
- Уурхайн хуримтлагдсан хөрөнгийн хэмжээ
- Үйлдвэрлэл явуулах нь тодорхой болсон төсөлд капиталжуулсан зардал
- Өмнөх жилүүдийн хуримтлагдсан зардлын тохиргоо гэх мэт.

Капиталжуулсан хүүгийн зардлын талаар:

- Хүү болон гадаад валютын ханшийн зөрүүг багтаасан бүртгэлийн бодлого
- Капиталжуулсан нийт хүүгийн дүн гэх мэт.

Ер нь хайгуул судалгаа, үнэлгээ, хөгжил болон бүтээн босгох бүх зардлыг сонирхол бүхий ордтой талбай тус бүрээр нь хуримтлуулан бүртгэх хэрэгтэй. Сонирхол бүхий ордтой талбайн хэмжээ нь тухайн ордыг цаашид ашиглах уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр тогтоогдоно. Хуримтлуулсан хайгуул судалгаа, үнэлгээ, хөгжил болон бүтээн босгох зардал тухайн сонирхол бүхий талбайг зарсан үнэ эсвэл уурхайн олборлолтоос олох нийт орлогоор бүрэн нөхөгдөх ёстой. Гэвч зарим хайгуул судалгаа, үнэлгээний зардал хөрөнгийн энэхүү шалгуурт нийцдэггүй. Хөгжлийн зардлыг тухайн сонирхол бүхий талбайн хувьд бүтээгдхүүн үйлдвэрлэл эсвэл худалдахаас өмнө хуримтлуулахдаа ирээдүйд энэ зардал нь бүрэн нөхөгдөнө гэсэн нотолгоотой байх ёстой.

Сонирхол бүхий хайгуулын талбайн ажил зогссон үед хуримтлагдсан бүх зардлыг алдагдалд бүртгэх учир ирээдүйн олборлолтоор олох орлого

гарч буй зардлын өнөөгийн дүнгээс үргэлж их байгаа эсэхийг хянах хэрэгтэй юм.

Хөгжил болон бүтээн босголтын төсөл эхлээс өмнө гарсан хайгуул, үнэлгээний ажлын зардлыг хуримтлуулаагүй байгаад дараа нь эргэж капиталжуулан орлого олж ажиллах үедээ хорогдол тооцохоор залруулга хийж болно. Ашигт малтмалтай сонирхол бүхий талбайн хуримтлагдсан зардал нь зөвхөн тухайн хэсэгт хамааргдах шууд ба шууд бус зардлаас бүрдэнэ. Харин үүнд шууд хамааралгүй ерөнхий болон удирдлагын зардлыг тайлант үеэр тооцно. Хөрөнгөнд зориулан авсан зээлийн зардлыг тухайн хөрөнгийн өртөгт тооцон капиталжуулна.

СТОУС –ын зарчмыг хайгуул судалгааны зардлын бүртгэлд нийтлэг баримтлах боловч уул уурхайн салбар өндөр хөгжсөн зарим улс оронд өөрийн онцлогтой бүртгэлийн аргачлалыг нэвтрүүлсэн байдаг. Тухайлбал:

#### *Австрали*

Австралийн бүртгэлийн стандартаар сонирхол бүхий талбайн хайгуул судалгааны зардлыг дараахи нөхцөлд капиталжуулдаг. Үүнд:

- Эдийн засгийн хувьд үр ашигтай орд илэрсэн бол дараагийн үе шатны ажил эхлэсэн эсэхээс хамаарахгүйгээр
- Ирээдүйд дараагийн шатны ажил эхлэх нь тодорхой байвал.

Ихэнх жижиг уурхайнууд болон хайгуул хийгчид дээрхи стандартыг баримтладаг. Томоохон уурхайнууд зардлын асуудалд илүү шуурхай ханддаг тул СТОУС-г мөрдлөг болгодог. Цаашид ашиглагдах ордын хайгуул судалгааны зардал капиталжих ёстой гэж үздэг.

#### *Бразил*

Бразилийн бүртгэлийн стандарт нь Австралийнхтай адил боловч доорхи нэмэлт нөхцөлийг тодруулсан байдаг. Үүнд:

- Олборлолт хийхээргүй орд илэрсэн бол зардлыг тухайн тайлант хугацааны зардалд бүртгэнэ.
- Ихээхэн нөөцтэй сонирхол бүхий талбайг тодорхой тогтооход нэн түвэгтэй байдгыг харгалзах хэрэгтэй.
- Цаашид ашиглагдах ордын хайгуул судалгааны зардал капиталжих ёстой.
- Хуримтлуулаагүй зардлыг буцаан капиталжуулах боломжгүй
- Гадаадын хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн өртөгт валютын ханшийн зөрүүг капиталжуулсан бол уг хөрөнгийг ашиглаж эхлэнээс хойш доод тал нь 5 дээд тал нь 10 жилийн хугацаанд хорогдол тооцно гэх мэт.

#### *Канад*

Канад улсын бүртгэлийн стандартаар сонирхол бүхий талбайн хайгуул судалгааны зардлыг дараахи нөхцөлд капиталжуулдаг. Үүнд:

- Эдийн засгийн хувьд үр ашигтай орд илэрсэн бол дараагийн үе шатны ажил эхлэсэн эсэхээс хамаарахгүйгээр
- Ирээдүйд ажил эхлэх нь тодорхой байх.

- Нэгэнт хуримтлуулаагүй зардлыг эргэж капиталжуулах боломжгүй
- Хайгуулын үеийн томоохон хөрөнгүүдийн төлбөрийг капиталжуулах хэрэгтэй бөгөөд уг хөрөнгийг хайгуул амжилтгүй болсон үед зардал болгон хасна.

Ихэнх хайгуулын компаниуд дээрхи стандартыг баримтладаг. Харин уурхайн компаниуд зардлын асуудалд илүү шуурхай ханддаг тул ерөнхийдөө СТОУС болон АНУ-н GAAP –г мөрдлөг болгодог.

#### *Индонез*

Хайгуулын лиценз эзэмшигч тухайн талбайд гарч байгаа хайгуул судалгааны зардлыг хуримтлуулахдаа доорхи 2 шалгуурыг авч үзнэ. Үүнд:

- Тухайн тайлангийн хугацааны эцсээр баланс гаргах үед хайгуулын ажил дуусах шатандaa ороогүй буюу үргэлжилсээр байх
- Олборлолтоос олох эсвэл уг ордыг зарах орлого хайгуулын зардлыг нөхөх нь тодорхой байх.

Удирдлагын зардлаас хайгуул, судалгаа, хөгжлийн төсөлтэй шууд холбогдох хэсэг л капиталжина. Хайгуулын явцад орсон орлого капиталжих зардлын дүнгээс хасагдана.

#### *Оросын Холбооны Улс*

Ирээдүйд олох орлогоор бүрэн нөхөгдөх бүх зардлыг хуримтлуулан бүртгэнэ. Хуримтлуулсан зардлыг тогтоосон стандарт нормтой харьцуулан үзэж илүү гарсныг нь алдагдал болгодог. Энэхүү нормыг өөр өөр ашигт малтмал бүхий ордуудын хувьд баримжаалдаг олон улсын практиктай харьцуулан үзэх хэрэгтэй.

#### *Өмнөд Африк*

Төсөвт бүртгэлд суурилсан бол гарч буй бүх зардлыг олборлолт эхэлтэл хуримтлуулан бүртгээд дараа нь төсөвтэй харьцуулан капиталжуулна. Томоохон уурхайн компаниудын хувьд бүртгэлийн дээрхи суурийг хэрэглэхгүйгээр НББОУС-н заалтыг мөрддөг. Хайгуулын компаниуд ихэнхдээ хайгуул хийж буй орд газартаа ойрын ирээдүйд (5 жилийн дотор) олборлолт хийж эхлэхээргүй байгаа бол хайгуул судалгааны зардлаа хуримтлуулдаггүй.

#### *Америкийн Нэгдсэн Улс*

Бүртгэлийн түгээмэл арга нь гарч буй зардлыг тайлант үед нь бүртгэх ба доорхи зарчмыг хэрэгжүүлнэ:

- Хасагдсан зардлыг буцаан капиталжуулахгүй
- Хайгуулын үеийн томоохон хөрөнгүүдийн төлбөрийг капиталжуулах хэрэгтэй бөгөөд уг хөрөнгийг хайгуул амжилтгүй болсон үед зардал болгон хасна гэх мэт.

Уул уурхайн салбарын бүртгэлийн хувьд нилээд тодорхой байх шаардлагатай ялангуяа энэ салбарт хөрөнгө оруулагчдын сонирхол анхаарлыг татдаг өөр нэг асуудал бол орлогын албан татварын бүртгэл, түүний аргууд /хойшлуулах, урьдчилан тооцож хорогдуулах гэх мэт/ мөн татвар ногдох

орлогоос хасагдах зардлууд, тэдгээрийг тодорхойлох аргачлал байдаг бөгөөд энэ асуудлыг тухайн улс оронд мөрдөж буй хууль зүйн бусад эрхийн актууд мөн томоохон төсөл хэрэгжүүлэгчийн Засгийн газартай байгуулсан гэрээний заалт зэрэгтэй уялдуулан боловсруулсан буртгэлийн бодлогод нарийвчлан тусгах шаардлагтай байдаг билээ.